



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/42

Есөнбулаг сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Шинжлэх ухаан, технологи, инновацын дэд зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллгааны журмын төслийг боловсруулах, Хөрөнгө оруулагчдын нэгдсэн зөвлөгөөны бэлтгэл ажлыг хангах, илтгэл, мэдээллийн төслийн хянаж, нэгдсэн стандартад нийцүүлэх ажлын хүрээнд хууль, эрх зүйн зөвлөх үйлчилгээ авах ажлыг "Режикс солишн" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д олгосугай.

2. Шаардагдах 18,800,000 (арван найман сая найман зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Санхүү төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

